



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар

А/В.

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт ард иргэдийнхээ эрүүл мэндийг сахин хамгаалах, иргэдэд эмийн эмчилгээг үр дүнтэй, чанартай, хүртээмжтэй хүргэх, эмийн зохистой хэрэглээг хэвшүүлэх үйлсэд олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Маралжин эмийн сан, Монос эмийн сангийн Ховд салбар, Дарви сумын эмийн сангийн хамт олон болон Мянгад сумын ахмадын хорооны дарга А.Цагаач нарыг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 120,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 120,000 төгрөг /нэг зуун хорин мянга/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ